



ГАЗРЫН ХАРИЛЦАА,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/212

Улаанбаатар хот

Гарын авлага батлах тухай

"Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоол, "Геодези, зураг зүйн тухай хууль"-ийн 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх хэсэг, "Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль"-ийн 10 дугаар зүйлийн 10.2.5 дахь хэсэг, Газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар хуралдааны тэмдэглэл, Бодлогын дэд зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Байр зүйн болон кадастрын зургийг солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх гарын авлага"-ыг хавсралтаар баталсугай.

2. Гарын авлагыг баримтлан Байр зүйн болон кадастрын зургийг солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Газрын удирдлагын алба /Р.Ганхуяг/-нд даалгасугай.

ДАРГА



А.ХҮРЭЛШАГАЙ

09 0001343



ГХГЗЗГ-ын даргын 2014 оны
/4/ тоот тушаалын хавсралт
2012

"БАЙР ЗҮЙН БОЛОН КАДАСТРЫН ЗУРГИЙГ СОЛБИЦЛЫН НЭГДСЭН ТОГТОЛЦООНД ШИЛЖҮҮЛЭХ" ГАРЫН АВЛАГА

Оршил

2002-2009 оны хооронд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр "Кадастрын зураглалын ба газрын бүртгэл" төсөл ГХГЗЗГ дээр хэрэгжсэн.

2002-2005 онд Улаанбаатар хот, 2006-2008 онд Сэлэнгэ, Дархан-Уул, Булган, Орхон, Төв, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн төв, сумдын төв, томоохон суурин газруудад байр зүйн болон кадастрын зураглал, газрын бүртгэлийг GPS-ийн солбицлын тогтолцоонд, ТМ тусгагд хийгдсэн юм.

Засгийн газрын 2009 оны 25-р тогтоол гарсантай /GPS-ийн солбицол, UTM тусгаг/ холбогдуулан GPS-ийн солбицолтой боловч ТМ тусгагд хийгдсэн байр зүйн болон кадастрын зургийг солбицлын нэгдсэн тогтолцоонд буюу UTM тусгагд шилжүүлэх зорилгоор энэхүү гарын авлагыг боловсруулав.

Гарын авлагыг бүх салбарт дагаж мөрдөнө.

Гарын авлага 2 бүлэгтэй.

Бүлэг 1-ийг GPS-ийн солбицлын тогтолцоонд, ТМ тусгагаар /масштабын итгэлцүүр нь 0,9996 Жишээлбэл: Улаанбаатар хот, Сэлэнгэ, Дархан-Уул, Булган, Орхон, Төв, Дундговь, Өмнөговь, Дорноговь аймгууд/ хийгдсэн газрын кадастрын зургийг, Бүлэг 2-ыг GPS-ийн солбицлын тогтолцоонд, ТМ тусгагаар /масштабын итгэлцүүр нь 1,0 буюу жишээ нь: Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад хийгдсэн газрын кадастрын зураг/ зургийг солбицлын нэгдсэн тогтолцоонд тус тус шилжүүлэхэд мөрдлөг болгоно.